

БОГИНО ХУГАЦААНЫ ТӨЛӨВ

Дэлхийн тодорхой бус байдал цаашид ч нэмэгдэх эрсдэлтэй байна. Дэлхийн тодорхой бус байдлын индекс түүхэн дээд түвшинд хүрээд байгаа бөгөөд худалдааны дайны цар хүрээ улам бүр тэлж болзошгүй байгаа нь дэлхийн эдийн засгийн идэвхжилийг хязгаарлах, инфляцыг өдөөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Түүнчлэн БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт, ОХУ-Украины дайн болон Ойрх Дорнодын тогтворгүй байдал зэрэг эдийн засаг, геополитикийн тогтворгүй байдлын эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн төлөвийг сулруулж болзошгүй байна.

Зэс, алтны үнийн өсөлт хадгалагдах төлөвтэй байгаа бол нүүрс, төмрийн хүдрийн үнэ сэргэх хандлага бага байна. Дэлхийн эдийн засгийн тодорхойгүй байдал нэмэгдэж, төв банкнуудын алт худалдан авалт өссөн нь аюулгүй хөрөнгийн эрэлтэд түлхэц болж, алтны үнийг өсөхөд хүргэлээ. Мөн цахилгаан автомашин, сэргээгдэх эрчим хүч, тоон өгөгдөл боловсруулах төвүүд, технологийн салбарын хурдацтай хөгжлөөс шалтгаалан зэсийн эрэлт нэмэгдэж үнэ өсөхөөр байгаа бөгөөд 2025 онд зэсийн дундаж үнэ 9,200 ам.долларт хүрэх төлөвтэй байна. Харин худалдааны дайн болон БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналтаас шалтгаалан нүүрсний үнэ 2025 оны эхний хагас жилийн байдлаар 66 ам.доллар болж, 41 хувиар буураад байна. Олон улсын шинжээчид нүүрсний үнэ богино хугацаанд огцом сэргэхгүй гэж үзсэн тул 2025 онд нүүрсний дундаж үнэ 70 орчим ам.долларт хадгалагдах төлөвтэй байна.

Эдийн засгийн өсөлт 2025 онд 6.5 орчим хувь байхаар тооцоолж байна. Салбаруудаар авч

үзвэл, хөдөө аж ахуй, боловсруулах салбарын үйлдвэрлэл сэргэж, үйлчилгээний салбаруудын үйл ажиллагаа тогтвортой үргэлжилж, эдийн засгийн өсөлтийг дэмжих төлөвтэй байна. Тухайлбал, Оюу толгойн баяжмал дахь зэс, алтны агуулга өссөнөөр дэлхийн зах зээл дээр эрэлттэй энэ үед өсөлтийг голлон дэмжихээр байна. Эрэлт талаас хөрөнгө оруулалт болон өрхийн хэрэглээ эдийн засгийн өсөлтийг үргэлжлүүлэн дэмжих хүлээлттэй байна. Мөн мал аж ахуйн салбарт эх малын тоо, төл бойжилт нэмэгдэх нөлөөгөөр нийт хөрөнгийн хуримтлал өсөж, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх төлөвтэй байна.

Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүдийн өсөлтийн хурд саарах хандлагатай байна. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн нөлөөгөөр 2025 онд ажиллагчдын тоо нэмэгдэхээр хүлээгдэж байна. Энэхүү өсөлтөд нийт ажиллагчдын 4 хүн тутмын нэг нь ажиллаж буй хөдөө аж ахуйн салбарын сэргэлтээс шалтгаалан тус салбарын ажиллагчдын тоо нэмэгдэх нь голлон нөлөөлж, нийт ажил эрхлэлтийн өсөлтийг дэмжихээр байна.

Инфляц 2025 оны эцэст төв банкны зорилтын дээд интервал орчимд байх төлөвтэй байна. Цахилгааны тарифын нэмэгдлийн нөлөөгөөр дотоодын бараа, үйлчилгээний үнэ өсөх хандлагатай байсны зэрэгцээ эрэлтийн гаралтай инфляц болон хүнсний инфляц өндөр байсан бол 2025 оны сүүлээс саарч, тогтворжихоор байна. Гэсэн хэдий ч цаашид геополитикийн тогтворгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, тээвэр логистикийн саатлаас үүдэн инфляц өдөөгдөх эрсдэлүүд хадгалагдаж байна.